

Орос улсын нягтлан бодох бүртгэлийн онцлог, Монгол улсад нягтлан бодох бүртгэл үүсэж хөгжихөд нөлөөлсөн нь

The Influence of Historic Characteristics of Russian Accounting in the Development of Accounting in Mongolia

Д. Моломжамц¹

Хураангуй

Монгол улсад шинжлэх ухааны үндэслэлтэй нягтлан бодох бүртгэл үүсэж хөгжсөн нь улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд маш чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. 1911 онд Богд хаант Монгол улс байгуулагдсанаар төрийн таван яам, Богдын шавь нарын захиргаа, аймгуудын чуулган даргын гүйцэтгэх захиргаа, жанжны болон суурин жасаад, хошуу тамгын газар зэрэг албан газрууд өөрсдийн санхүү, албан татварын орлого, засаг захиргааны зардлын мөнгөн хөрөнгө, эд зүйлийн орлого зарлагын хөдөлгөөнийг бүртгэж данслах ажлыг хийж эхэлсэн. Улмаар 1921 онд Монгол оронд ардын хувьсгал ялсанаар эдийн засаг, бүртгэл санхүүгийн орчин үеийн системийг үүсгэн хөгжүүлэх үндэс суурь тавигдсан. Энэхүү үйл хэрэгт тухайн үеийн ЗХУ-ын эрдэмтэд, бүртгэлийн мэргэжилтнүүд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Харин Орос улсад нягтлан бодох бүртгэл нь Итали, Франц, Герман, Англи зэрэг барууны бусад өндөр хөгжилтэй улс орнуудтай харьцуулахад нилээд хожуу үүсэж хөгжсөн, өөрөөр хэлбэл тус улс тэдгээр улс орнуудын данс, бүртгэлийн туршлагыг судлан нэвтрүүлсэн байдаг. Тиймээс Орос улсад нягтлан бодох бүртгэл хэрхэн үүсэж хөгжсөн түүх болон Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн хөгжлийн онцлогийг энэхүү өгүүлэлд товч авч үзсэн болно.

Түлхүүр үгс: нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн үүсэл хөгжил, бүртгэлийн түүх

Abstract

The inauguration of science-based accounting system in Mongolia has played an important role in Mongolian social and economic development. Many offices and organizations including five state ministries, administration office for Bogda's pupils, the executive authority of banner, banner office, launched a campaign of accounting and recording the finance, tax income, administrative expenses and balance of income and expenditure. Needless to say here, it is unanimously agreed that the modern system of economy and finance was developed after the People's Revolution in 1921, particularly, thanks to Russian scientists and financial professionals. In fact, the accounting in Russia developed comparatively later than one in some Western highly-developed countries such as Italy, France, Germany, and England, and Russia introduced their experiences of the accounting system. As a result, this paper focuses on the history and characteristics of developing the accounting system in Russia and Mongolia.

Keywords: accounting, development of accounting system, history of accounting system

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн профессор, доктор
E-mail: molomjamts0112@yahoo.co.jp

I. Орос улсад нягтлан бодох бүртгэл үүсэж хөгжсөн нь

Орос орны эдийн засгийн амьдрал ямагт төрийн хяналтан дор явагддаг байсан тул бүртгэл нь үргэлж төрийн хууль тогтоомжийн нэг бүрэлдэхүүн хэсэг болсоор ирсэн гэж үздэг. Тиймээс Оросын нягтлан бодох бүртгэлийн түүх бол Оросын төрийн түүх юм. Орос улсын нягтлан бодох бүртгэлийн сэтгэлгээний гүн гүнзгий утга агуулгыг түүнийг илэрхийлж буй хэд хэдэн чухал шинж тэмдгээр ангилж авч үздэг. Төрийн аж ахуй нь үндсэндээ тэр үеийн ван, язгууртнуудын хувийн өмч байсан тул албан татварын хэмжээг тусгайлсан дүрэм журмаар тогтоодоггүй байсан. Аж ахуйн энэ онцлог шинж нь Орос улсын нягтлан бодох бүртгэлд болон бүртгэлийн анхны зарчмууд бүрэлдэн тогтоход нөлөөлсөн байна (Соколов нар, 2006).

Оросын нягтлан бодох бүртгэлийн зарчмууд нь аж ахуйн үйл ажиллагааны, ялангуяа үнэн алдартны сүм хийдийн үйл ажиллагааны бүх талыг тусгахад чиглэгдэж байсан. Үүнд хамжлагат ёстой холбоотойгоор аж ахуйн үүрэг хариуцлагыг хуваарилах нарийн түвэгтэй дүрэм журам нөлөөлж байсан. Тухайлбал, сүм хийдийн аж ахуй дахь үүрэг хариуцлагын зохион байгуулалт, ажил үүргийн хуваарилалтыг тухайн үеийн дүрэм, журамд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Эд хогшлыг данслах, аж ахуйн даамлын өмнөх жилүүдийн өр авлагыг албадан төлүүлэх;
2. Аж ахуйн даамал нь материалын үнэт зүйлстэй холбоотой бүх үүрэг хариуцлагыг няравтай хамтран хуваалцах;
3. Агуулахын түлхүүрийг нярав хадгалдаг, харин аж ахуйн даамал агуулахыг битүүмжлэх буюу лацаддаг;

4. Мөнгөн орлогод зориулан аж ахуйн даамал болон нярав нөхөж бичдэг тусгай дэвтэр хөтөлдөг;
5. Гурил, үр тарианы бүртгэл нь орлого ба зарлагын хоёр тусгай дэвтэр хөтлөхийг шаарддаг байсан;
6. Хувцас болон бусад эд зүйлийн тухайд мөн тусад нь ийм дэвтэр хөтөлдөг байсан;
7. Тусгай дэвтрүүдийг жилийн турш хөтөлж үнэн алдартны хамбад явуулах ёстой гэх мэт.

XVII зууны үеийн Оросын бүртгэлийн системд орлогын бүртгэл нь зардлын бүртгэлийн нэг хэсэг болж байсан бөгөөд энэ нь гол төлөв бараа материалын үнэ бүхий зүйлд хяналт тавих, аж ахуйн үйл ажиллагааны баримт мэдээг дэс дараалан бүртгэхэд чиглэгдэж байсан байна. XVII зуунаас хойш сүм дуган барьж байгуулах, худалдаачдын дэн буудал, хөлөг онгоцны үйлдвэрлэлийн бүртгэлийн системд шинэчлэл хийхтэй холбоотойгоор хэд хэдэн бүртгэлийн бичиг баримтыг боловсруулсан. Орос улсад үйлдвэрлэлийн бүртгэл XVII зууны II хагаст бүрэлдэн бий болсон гэж үздэг. Орлого, зарлагын ерөнхий дэвтэр нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зардал болон өртгийн тооцооллыг агуулсан төсвийн дэвтэр, ажилчин албан хаагчидтай хийх тооцооны дэвтэр зэрэг тасралтгүй бүртгэлийн шинжтэй байсан.

Төмөрлөгийн үйлдвэрт 1) хуулан бичих дэвтэр, 2) эд хогшил данслах дэвтэр, 3) орлого ба зарлагын дэвтэр гэсэн гурван төрлийн дэвтрийг хөтөлдөг байжээ. Бүртгэл нь ерөнхийдөө төвлөрсөн шинжтэй байсан. Орлого ба зарлагын дэвтэр дэх бичилт нь төмөрлөгийн үйлдвэрийн зохион байгуулалтаас үл хамааран дэс дараалсан бичилтийн зарчим дээр тогтож

байв. Зарлагын дэвтэр нь лам болон эрхэлсэн түшмэлийн гарын үсэг зурсан төлбөрийн хүснэгтийг өөртөө агуулж байсан. Бүртгэлд тусгаж буй зүйлүүд нь үндсэндээ биет хөрөнгө биш мөнгөний хөдөлгөөн байсан бөгөөд өдөр тутмын зардлыг кассын нярав бэлэн мөнгөөр төлдөг байсан. Харин нягтлан бодогч данс хөтлөхийн зэрэгцээ няравын үүргийг нэгэн зэрэг давхар гүйцэтгэдэг байв.

Зоосон мөнгө цутгах газрууд үйлдвэрлэлийн үе шатаар бүртгэлээ хөтөлдөг байсан. Энд:

1. Түүхий эд болон хаягдлыг орлого болгох,
2. Гаалийн татварын алтны цэвэр болон бохир жинг мөнгөнд шилжүүлэх,
3. Санхүүгийн үр дүн болон мастеруудын цалингийн бичилт зэргийг тусгасан тусгай дэвтрүүдийг хэрэглэж байсан.

Энэ мэтчилэн аж үйлдвэр, барилгад энгийн бүртгэлийг ашиглаж байсан бөгөөд үүний зэрэгцээ зардлын бүртгэл, өөрийн өртгийн тооцоолол зэргийг бас ашиглаж байжээ.

Дундад зууны үеийн Орос улсад худалдааны бүртгэл нилээд хөгжсөн гэж үздэг. Худалдааны бүртгэлийн гол цөм нь тооцооны дансад бүхий төсвийн бүртгэл байсан бөгөөд үүнийг анх зээлийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. Зээлийн үйл ажиллагааны эргэлтийн дансыг Оросод тусгай самбар - картан дээр хөтөлдөг байв. Жишээ нь, Новгород хотод зээл олгох үед өрийн баримт өгч бичилт хийдэг байсан. Худалдаанд барааны бүртгэлд гол төлөв аж ахуйн ажил гүйлгээг бүртгэх өртгийн бүдүүвч бүхий хэсэгчилсэн аргыг ашиглаж байсан, гэхдээ энэ нь биет өртгийн биш барааны биет бүртгэл байв.

Улсын аж ахуйд бүртгэлийн үндэс нь эд

зүйлийг данслах бичилт байсан бөгөөд энэ нь эхэн үедээ харуул хүлээлцэх дэвтэртэй төстэй байсан. Орон нутгийн захиргаа бүхэн татвар хураах ажлыг эрхэлдэг байсны зэрэгцээ тэдгээр захиргаад нь орон нутгийн зардлыг нөхөхийн тулд татварын хувь хэмжээг тогтоох, мөнгөөр ноогдуулах тусгай дэвтрийг нээж хөтөлдөг байсан. Орон нутгийн захиргааны бүрэлдэхүүнд багтаж байсан хотуудаар татвар ноогдуулалттай холбоотой бүх бичилтүүд, орлого - зарлагын дансыг хөтөлдөг байв. Жилийн эхэнд хот бүр өмнөх оны татварын зөрүү буюу дутууг татварын нэр төрлөөр нь бичиж тайлагнадаг байв. Өдөр тутмын бичилтийг анхны баримтанд тулгуурлан хийж гүйцэтгэдэг, үүний зэрэгцээ хот бүр орлогын төрлүүдээр бүртгэл хөтөлдөг байсан (Фролова, 2010).

М.Алексее хааны үед бүртгэл тооцооны асуудал эрхэлсэн тусгай захиргааг байгуулсан бөгөөд энэхүү захиргааны ажилтнууд янз бүрийн байгууллагуудын тооцооны дэвтрийг хянаж шалгах, амбан захирагч, мужийн цэргийн захирагч болон бусад албан тушаалтнуудад хуваарилж өгсөн төсвийн гүйцэтгэлийг хянах, захиргааны байгууллагуудад ашиглагдаагүй мөнгөн хөрөнгийг улсын төсөвт эргүүлэн татаж төвлөрүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэдэг байв. Бусад хотуудад хяналт шалгалтыг явуулахын тулд хариуцсан албан тушаалтнуудыг бүртгэлийн дэвтэр ба холбогдох нотлох баримтуудын хамт Москвад дуудан ирүүлдэг байв (Соколов нар, 2006).

Энэ мэтчилэн дундад зууны үеийн Орос улсад бүртгэлийн хөгжил нь бичиг үсэг, математикийн мэдлэгийн доод түвшнээс алгуур эрчтэй урагшлан хөгжсөн гэж үздэг.

Харин I Петр хааны эрин үед Орос оронд

Зураг 1. I Петр хаан



бүртгэл, хяналтын асуудлыг онцгой анхаарч бүртгэлийн зохион байгуулалттай холбоотой заавар журам, төрийн баримт бичгүүд хэвлэгдэн гарсан. 1714 оны төрийн баримт бичигт бүртгэлийн дараах асуудлуудыг тусгасан байдаг. Үүнд:

1. Бүртгэлийн бичилт нь цаг хугацаандаа хийгддэг байх, өөрөөр хэлбэл “бүртгэл нь шуурхай байх”,
2. Орлого, зарлагын дэвтрийг өдөр бүр хөтлөх,
3. Хариуцсан албан тушаалтнууд бүртгэлийг нягт нямбай хөтлөх зэрэг болно.

Оросын нягтлан бодох бүртгэлийн түүхэн дэх нэг томоохон үйл явдал бол 1722 онд хэвлэгдсэн Хөлөг онгоцны үйлдвэр болон тэнгисийн флотын удирдах газрын дотоод журамд нягтлан бодогч, дебет, кредит гэсэн нэр томъёо, үгсийг анх хэрэглэсэн явдал бөгөөд энэхүү дотоод дүрэм, журмыг бусад томоохон үйлдвэр аж ахуйн газруудад загвар болгон хэрэглэх шаардлагатай

гэж онцолсон байна. Түүнчлэн энэхүү дүрэм журамд материалын биет өртгийн бүртгэлийг нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнгээр хөтлөх нарийн системийг урьдаас зааж өгсөн байна.

Зураг 2. Тэнгисийн цэргийн усан онгоцны үйлдвэрийн дотоод журам (1722.04.05)



Агуулахын няравууд хуудсыг нь дугаарлаж үдсэн, нярав болон хянагч гарын үсэг зурж баталгаажуулсан материалын хоёр төрлийн дэвтрийг хөтөлдөг байв. Эхний дэвтэр нь цаг хугацааны дэс дараалал бүхий бичилт хийдэг журнал бөгөөд түүнд орлого, зарлагын үйл ажиллагааг бичдэг байсан.

Материалыг тавьж олгох үед зөвхөн бэлнээр олгох тушаалыг үндэслэдэг бөгөөд энэ үед хянагч заавал гарын үсэг зурдаг, журнал болон тушаалд агуулахын нярав ба материалыг хүлээн авагч нар мөн гарын үсэг зурдаг байв. Бусад байгууллагатай байгуулсан гэрээний биелэлтийн бүртгэлд зориулан тусгай дэвтрийг хөтөлдөг байсан. Материалын орлогын бүртгэлийн эдгээр баримтууд нь Орос улсын хувьд анхныхад тооцогддог байна.

Ийнхүү тэнгисийн флотын дүрэм журам нь Оросын нягтлан бодох бүртгэлийн системд, ялангуяа агуулахын бүртгэлийн нийт улсын хэмжээний аргачлал, анхан шатны баримтын тусламжтайгаар аж ахуйн үйл ажиллагааны бүх мэдээ баримтыг хууль ёсны болгох зарчмыг тууштай хэрэгжүүлэхэд асар их нөлөө үзүүлсэн байна. Бүртгэлийн бичилтийг хийхдээ үнэн зөв болох нь нотлогдоогүй баримт материалыг ашигладаггүй байсан. Бүртгэлийн системд агуулахын нөөцийн бүртгэл гол байр суурь эзэлдэг байсан бөгөөд энэ нь барилга, аж үйлдвэр, цэрэг армийн материалын хангамжийн бүртгэлийг тусгай дүрэм журмаар нарийн чанд зохицуулдаг байсантай холбоотой юм (Фролова, 2010).

Улсын мэдлийн төмөрлөгийн үйлдвэрүүдэд материалын бүртгэлийн дэвтэрт “С” үсгээр кредитийг, “Д” үсгээр дебетийг тэмдэглэдэг байсан. Энэхүү материалын бүртгэлийн дэвтэрт бараа материалыг 12 бүлгээр ангилж бүртгэдэг байв.

I Петр хааны үед Оросын нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалт нь засаг захиргааны шинэчлэлтэй нягт холбоотой байв. Энэ үед хэд хэдэн төрлийн хууль эрх зүйн актууд, заавар журмыг батлан мөрдүүлж байжээ. Тэдгээр дүрэм журмын ихэнхийг баруун Европын орнуудаас, ялангуяа Шведийн туршлагыг судалсны үндсэн дээр боловсруулсан байна. Энэ шинэчлэл нь:

1. Өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдалд тавих хяналтыг чангатгах,
2. Улсын сангийн орлогыг нэмэгдүүлэх гэсэн хоёр зорилгод чиглэгдэж байсан.

Түүнчлэн I Петр хааны үед Орос улсад аж үйлдвэрийн бүртгэл асар хурдацтай хөгжсөн гэж үздэг. Үйлдвэрийн газруудад

эхлээд үйлдвэрлэлийн тусгай нэгж хэсгүүдийн удирдлагад зайлшгүй шаардлагатай аж ахуйн бүх ажил гүйлгээг тасралтгүй баримтжуулах; эд хогшлыг бүртгэх, тайлан бэлтгэх үйл ажиллагааг зохицуулах; өртөг зардлыг тооцох орчин үеийн аргыг хэрэглэх; бүртгэлийн мэдээллийг задлан шинжлэх боломжийг бий болгосон. Гэхдээ аж үйлдвэрийн бүртгэлд дансны давхар бичилтийг ашигладаггүй байсан. Энэ нь Оросын нягтлан бодогчид зардлыг бүртгэх, хэмжихтэй холбоотой биет бүртгэлийг илүүд үздэг байсантай холбоотой байв (Палий, 1994).

Зураг 3. Михайл Дмитриевич Чулков,
Оросын зохиолч, нийтлэлч,
түүхч (1743 – 1792)



Орос оронд дансны давхар бичилтийг нэвтрүүлэхэд Баруун Европын орнуудын нягтлан бодох бүртгэлийн ном, зохиол бүтээлүүд ихээхэн нөлөө үзүүлсэн. Нягтлан бодох бүртгэлийн бүтээлүүдийг гадаад хэлнээс Орос хэлэнд орчуулсан хамгийн анхны орчуулагч сэхээтнүүдийн нэг бол дансны давхар бичилтийг талархан дэмжигч М.Д.Чулков байв.

Түүний орчуулгын бүтээлд Итали, Франц болон Германы бүртгэлийн хэлбэрүүдийг дэлгэрэнгүй авч үзсэн байдаг (Соколов нар, 2006).

Оросын томоохон худалдааны байгууллагуудад хэрэглэж эхэлсэн худалдааны нягтлан бодох бүртгэл нь хэд хэдэн онцлогтой байсан. Энэ үед ихэнх нягтлан бодогчид өөрийн өртгийн үнэлгээний зарчмыг баримталж байв. Худалдааны нягтлан бодох бүртгэлийн систем нь 1800 оны Банкны дүрэм, 1834 оны худалдаачдын худалдааны дэвтэр хөтлөх журмын тухай хуулиар тус тус зохицуулагддаг байсан. Эдгээр хууль эрх зүйн баримт бичгүүдэд худалдааны байгууллагуудын бүртгэлийн хэлбэр ба бүртгэлийг хөтлөн явуулахад баримтлах дүрэм журмыг зааж өгсөн байдаг. Худалдааны бүртгэл нь бөөний худалдааны, жижиглэнгийн худалдааны ба жижиг худалдаа эрхлэгчдийн гэсэн гурван хэсэгт хуваагдаж байв. Эдгээр бүртгэлийг:

1. Барааны – барааны бүртгэлийн дэвтэр;
2. Кассын – мөнгөн орлого ба төлбөрийн бүртгэлийн дэвтэр;
3. Тооцооны – үйлдвэрлэлтэй холбоотой тооцоог хөтөлдөг дансдын жагсаалтыг багтаасан дэвтэр гэсэн гурван дэвтэрт хувааж үздэг.

Жижиглэнгийн худалдаа болон жижиг худалдааны байгууллагад энгийн бүртгэлийг, харин бөөний худалдааны байгууллагууд дансны давхар бичилтийн аргыг хэрэглэж байсан. Иймээс бөөний худалдааны байгууллагууд дараах дэвтрийг нэмж хөтөлдөг байжээ. Үүнд:

1. Аж ахуйн үйл ажиллагааны бүх баримт мэдээг дэс дараалан бүртгэх журнал;
2. Бүх үндэслэсэн баримт, захидал харилцааны хуулбарын дэвтэр;
3. Хөтөлж буй дансдын дэвтэр;

4. Хөтөлсөн баримтын дэвтэр;
5. Аж ахуйн үйл ажиллагааны бүх баримт мэдээг системтэй бүртгэх Ерөнхий дэвтэр зэрэг болно.

Ийнхүү Орос оронд нягтлан бодох бүртгэл I Петр хааны үеэс харьцангуй хурдацтай хөгжиж ирсэн бөгөөд XIX зууны эхний хагаст нэрт нягтлан бодогч К.И.Арнольд, И.Ахматова, Э.А.Мудрова ба И.С.Вавилова нарын хөдөлмөр, үр бүтээлийн ачаар Оросын нягтлан бодох бүртгэлийн чиглэл бүрэлдэн бий болсон гэж үздэг (Соколов нар, 2006).

Харин 1917 оны Октябрийн хувьсгалын үр дүнд үүсэж буй болсон Зөвлөлт засгийн он жилүүдэд Оросын нягтлан бодох бүртгэл нь социалист нийгмийн өмч хөрөнгийг бүртгэж хянах, тайлагнах нилээд нүсэр тогтолцоо болон хөгжсөн юм. Тухайн үеийн ЗХУ-ын олон арван эрдэмтэд, бүртгэлийн мэргэжилтнүүд улс ардын аж ахуйн бүх салбарт нягтлан бодох бүртгэлийн мемориал ордер болон журнал ордериин системийг нэвтрүүлэх, түүнийг боловсронгуй болгох, баланс тайлан болон төлөвлөгөөний биелэлтэнд нөлөөлсөн хүчин зүйлийг задлан шинжлэх аж ахуйн үйл ажиллагааны иж бүрэн шинжилгээг хөгжүүлэхэд асар их хувь нэмэр оруулсан билээ. Чухам энэ үед манай оронд шинжлэх ухааны үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийг хэрэглэж эхэлсэн бөгөөд энэхүү үйл хэрэгт хуучин ЗХУ-ын эрдэмтэд, бүртгэлийн мэргэжилтнүүд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

II. Монгол улсад нягтлан бодох бүртгэл үүсэж хөгжсөн нь

Олон зууны туршид Монгол орны эдийн засгийн үндсэн салбар нь хувийн жижиг, тархай бутархай нүүдлийн мал аж ахуй

болж байсан, үйлдвэр, худалдаа, тээвэр, холбоо, барилга зэрэг эдийн засгийн салбар болон нягтлан бодох бүртгэл хөтлөхийг шаардахуйц үндэсний томоохон аж ахуйн нэгж, пүүс компани байгаагүй зэрэг нь энгийн тоо бүртгэлээс өөр бүртгэл, мэдээллийн болон хэмжүүрийн нэгдсэн систем үүсэж хөгжих боломжгүй байсан.

Олон мянган малтай феодалын болон сүм хийд, жасын аж ахуй, түүнчлэн малын гаралтай түүхий эдийг боловсруулах, уран дархан, гэр ахуйн модон эдлэл хийх, дээл хувцас оёх, үс засах, хоолны газар ажиллуулах зэрэг худалдаа үйлчилгээний жижиг газрууд нь улс орны эдийн засгийн системд багагүй үүрэгтэй байсан хэдий ч үйлдвэрлэл хөгжсөн бусад улсын адил үйлдвэр аж ахуйг удирдах, зохион байгуулах, бүртгэл хяналтыг явуулах байнгын үйл ажиллагаа маш дутмаг байсан тул бүртгэл тооцооны боловсронгуй систем төдийлөн нэвтрээгүй байна.

Зураг 4. 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагчид



1911 онд Богд хаант Монгол улс байгуулагдсанаар төрийн таван яам, Богдын шавь нарын захиргаа, аймгуудын чуулгандаргын гүйцэтгэх захиргаа, жанжны болон суурин жасаад, хошуу тамгын газар зэрэг албан газрууд өөрсдийн санхүү, албан татварын орлого, засаг захиргааны зардлын мөнгөн хөрөнгө, эд зүйлийн орлого зарлагын хөдөлгөөнийг бүртгэж данслах ажлыг хийж эхэлсэн. Монгол улсын орлого, зарлагын төсвийг 1914-1915 оноос эхлэн бүдүүвчлэн зохиож, түүний бүртгэлийг энгийн системээр ерөнхийлөн хөтөлж байсны үр дүнд 1915 онд улсын сангийн бүх орлого, зарлага түүхэнд анх удаа албан ёсоор мэдээлэгдсэн байна (Намжим, 2000).

Зураг 5. Нийслэл хүрээ, 1920-иод он



Харин 1921 онд Монгол оронд ардын хувьсгал ялснаар эдийн засаг, бүртгэл санхүүгийн орчин үеийн системийг үүсгэн хөгжүүлэх үндэс суурь тавигдсан. 1921 оны 3-р сард байгуулагдсан Ардын түр засгийн газрын гурван яамны нэг нь Сангийн яам байсан. 1921 оны 7-р сарын 9-ний өдөр хуралдсан Ардын засгийн хэргийг түр захиран шийтгэх газрын тэргүүлэгчдийн 2-р хурлаар “Төмөр утас, телефон хороо, утасгүй цахилгаан мэдээний хороо” зэрэг газрыг улсын мэдэлд авч, 1921 оны 7-р сарын 18-ны өдөр хуралдсан Түр засгийн газрын 5-р хурлаар Нийслэл хүрээний

цахилгаан гэрлийн хороог хурдавчлан сэргээж ажиллагаатай болгохыг Сангийн яаманд даалгаж тэдгээр газруудын аливаа орлого, зарлагыг төлөвлөн бодуулсугай” (Улсын түүхийн төв архив, Фонд №1 (11)) гэжээ.

Зураг 6. Улаанбаатар хот, 1950-иад он



Ардын засгийн газар 1921 оны 10-р сарын 16-нд Монголын харилцан туслалцах хоршоог байгуулах шийдвэр гаргасан бөгөөд 1921 оны 12-р сарын 16-нд уг хоршооны анхдугаар хурлаар хоршоог албан ёсоор байгуулж улсаас 10 мянган лан мөнгө олгосноос гадна харилцан туслалцах хоршоонд анх 116 гишүүн элсэж 8,300 лангийн хувь хөрөнгө нийлүүлжээ (Улсын түүхийн төв архив, Фонд №1 (35)).

1923 оноос Налайхын чулуун нүүрсний уурхай, хэвлэлийн жижиг үйлдвэр, Алтанбулагийн булигаарын завод, Монголтранс зэрэг улс, хоршооллын үйлдвэр, аж ахуйн газрууд шинээр байгуулагдаж, тэдгээрийг нарийн тодорхой бүртгэл, тайлантай болгох шаардлагатай болсон тул 1923-1924 оноос орчин үеийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэж эхэлсэн байна. Энэ тухай Сангийн яамны сайд Б.Дорж 1924 оны 11-р сард хуралдсан улсын анхдугаар их хуралд тавьсан илтгэлдээ “Тус улсын дотор нягтлан бодох

данс ер үйлдэж явсангүй бөгөөд ардын засаг байгуулагдсанаас хойш харъяат яамны дансыг гадаад улсын давхар нягтлан бодох журмаар үйлдсэн боловч мэдэж боловсорсон хүмүүс цөөн, тэр бүр бүрэн төгсөөр явуулж чадаагүй учир ... энэ жил (1924 он) олон аймаг шавиас сурч чадахуйц сэргэлэн ухаантай хүмүүсийг зарлан ирүүлж сургууль байгуулан боловсруулах нь нэн чухал байна” гэж тэмдэглэсэн байна (Улсын анхдугаар их хурлын сонин, 2-р дэвтэр).

Манай улсад 1924 оны 6-р сард Сангийн яамны дэргэд эхлээд гаалийн, дараа нь нягтлан бодохын түр курсыг зохион байгуулсан байна. Үүнийг 1929 оноос нягтлан бодохын жинхэнэ сургууль болгон өргөжүүлж, 1935-1936 оны хичээлийн жилээс санхүүгийн техникум, 1946 оноос санхүү, эдийн засгийн техникум болгон зохион байгуулсан.

1924 оны 11-р сарын 1-нд Монголын харилцан туслалцах хоршооны дэргэд хоршооны түр сургууль байгуулснаар улс хоршооллын үйлдвэр, худалдаа, аж ахуйн байгууллага, банкны данс бүртгэлийн боловсон хүчнийг бэлтгэх болсон.

Зөвлөлтийн мэргэжилтэн А.Д.Грижавскийн удирдлаган дор БНМАУ-ын Сангийн яамны хэлтсийн эрхлэгч Н.Лувсансодном, нягтлан бодогч Ч.Түмэн нар 1924 онд төсвийн байгууллагуудын хяналт шалгалт ба нягтлан бодох бүртгэлээр арга зүйн заавар боловсруулсан нь Монгол улсад анх удаа нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр гарсан баримт бичиг байлаа. Үүний дараа 1949 оны 9-р сард Ч.Түмэн “Үйлдвэрийн нягтлан бодох бүртгэлийн сурах бичиг” номыг хэвлүүлсэн нь Монгол хэл дээр гарсан нягтлан бодох бүртгэлийн анхны ном байсан бөгөөд

1949 оны 11-р сард ЗХУ-ын мэргэжилтэн А.А.Юрковтой хамтран түүний уншсан лекцүүдэд тулгуурлан “Нягтлан бодох бүртгэлийн үндэснүүдийн сурах бичиг” номыг хэвлүүлсэн байна. Энэ бүхэн нь манай улсад шинжлэх ухааны үндэслэлтэй нягтлан бодох бүртгэл үүсэж хөгжих үндэс, суурь болсон байна (Моломжамц, 2016).

1920-иод оны сүүлчээр манай улсад уригдан ажиллаж байсан Зөвлөлтийн мэргэжилтнүүд өөрийн орны туршлагад тулгуурлан нягтлан бодох бүртгэлийн энгийн системийг манай улсын төв ба орон нутгийн бүх санхүү, төсөвт байгууллагуудад хэрэглүүлэхээр холбогдох заавар журмыг боловсруулан гаргаж, түүнийг мөрдөж байсан. Энэхүү бүртгэлийн энгийн систем нь 1968 он хүртэл хөтлөгдсөн байна.

Зураг 7. Улаанбаатар хот, 1960-аад он



Үүний зэрэгцээ 1930-аад оноос үйлдвэр аж ахуйн газар, байгууллагуудын бүртгэл хөтлөлтөнд нэвтэрч эхэлсэн мемориал-ордерийн системд үндэслэсэн нягтлан бодох бүртгэлийн давхар бичилтийн янз бүрийн хэлбэр, загварууд нь 1962 онд журнал-ордерийн системд шилжих хүртэлх хугацаанд хэрэглэгдэж ирсэн. Эндээс үзвэл 1960-аад оноос өмнө манай улсын улс ардын аж ахуйн салбаруудад хөтлөгдөж байсан нягтлан бодох бүртгэлийн хэлбэр маягтууд нь ерөнхийдөө мемориал-ордерийн системд тулгуурлаж байсан боловч салбар тус бүр

өөр өөр дансны төлөвлөгөөтэй, хөтөлж буй хураангуй болон дэлгэрэнгүй бүртгэлийн маягтууд нь хүртэл өөр хоорондоо харилцан адилгүй, янз бүр байсан байна (Лодой нар, 1985).

Зураг 8. Улаанбаатар хот, 1970-аад он



1960-аад он гэхэд манай улсын хөдөө аж ахуйд нэгдэлжих хөдөлгөөн ялж, социалист орнуудын техник-эдийн засгийн тусламжаар улс ардын аж ахуйн янз бүрийн салбарууд бэхжиж, улс орны нийгэм, эдийн засгийн амьдралд томоохон өөрчлөлт гарсан. Энэ бүхэн нь манай улсын аж ахуйн бүх салбарт ашиглаж буй бүртгэл тооцооны нүсэр ажиллагааг дэвшилтэт хэлбэр болох журнал-ордерийн системд шилжүүлэх шаардлагыг зүй ёсоор тавьсан. Манай улсын үйлдвэр, аж ахуйн газруудын бүртгэл тайлагналын тогтолцоонд 1962 оноос нэвтрүүлсэн энэхүү журнал-ордерийн системийг 1990 он хүртэл ашиглаж ирсэн юм.

Зураг 9. Улаанбаатар хот, 1990 он



Харин 1990-ээд он буюу Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлснээс хойш манай улсын нягтлан бодох бүртгэлийн салбарт томоохон өөрчлөлт гарч 1993 онд анх удаа “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, 1997 онд

“Аудитын тухай хууль”-ийг тус тус баталж гаргасан нь зах зээлийн харилцаанд нийцүүлэн Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу нягтлан бодох бүртгэл, тайлагналын тогтолцоогоо өөрчлөн шинэчлэх боломж бүрдсэн билээ.

Ашигласан материал

1. Баканов, М. И., Шеремет, А. Д. (1997). *Теория экономического анализа*, Финансы и статистика, Москва
2. Лодой, С., Лүндэн, С. (1985). *Нягтлан бодох бүртгэлийн онол*, Улаанбаатар
3. Моломжамц, Д. (2016). *Санхүү, эдийн засгийн шинжилгээ*, Улаанбаатар
4. Моломжамц, Д. (2017). *Нягтлан бодох бүртгэлийн түүх ба онол*, Улаанбаатар
5. Намжим, Т. (2000). *Монголын аж ахуй, эдийн засаг – түүхэн гурван үед*, Улаанбаатар
6. Палий, В. Ф. (1994). Бухгалтерский учет до и после Луки Пачоли, *Бухгалтерский учет*, 8
7. Панков, Д. А. (1998). *Бухгалтерский учет и анализ в зарубежных странах: Учебное пособие*, Экоперспектива, Минск
8. Соколов, Я. В., Соколов, В. Я. (2006). *История бухгалтерского учета*, Финансы и статистика, Москва
9. Улсын анхдугаар их хурлын сонин, 2-р дэвтэр
10. Улсын түүхийн төв архив, Фонд №1 (11)
11. Улсын түүхийн төв архив, Фонд №1 (35)
12. Фролова, Т. А. (2010). *Бухгалтерский учет: Конспект лекций*, Таганрог